

**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын  
“Орхон хөгжил” ХК-ийн  
2022 оны газар тариалангийн  
үйлдвэрлэл болон үйл ажиллагааны тайлан**

1. Тариалалтын талаар:

Тайлант 2022 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Мөн тоног төхөөрөмжөө шинэчлэн хор цацагч, үрлүүр, сийрүүлүүр хийсэн. 2021 онд 1 ширхэг комбайн, трактор худалдаж авсан.

Тариалалтыг 5-р сарын 04-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд нийт 725 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 130 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

2. Ургац хураалтын талаар;

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 4 трактор, 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 700 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-р сарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-р сарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Ургац хураалт өөрийн автомашин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

3. Үтрэмийн ажлын талаар;

Хураасан будаагаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн “Өгөөж гурил” ХХК, “УБ гурил” ХХК-д мөн өмнөх 2021 оны үлдсэн улаан буудайг “ХААДСан”, “Түмэн шувуут” ХХК, “Амжилт” ХХК, “Гранд пиглет” ХХК-д борлуулсан болно.

2022 онд 308 га-д улаан буудай тариалж 1 га-гаас 13 цн буюу нийт 400,4 тн ургац хураасан бөгөөд үүнээс үрэнд 50 тн будаа хадгалж, 348,97 тн улаан буудай борлуулж, 327942,6 сая төгрөгний орлого, 628,6 га-д рапс тариалж 1 га-гаас 3 цн буюу нийт 188,6 тх ургац хураан авч борлуулан 377200,0 сая төгрөгний орлого, 2021 оны үлдэгдэл улаан буудайг борлуулж 178294,7 төгрөгний орлого олж, үүнээс 729840,5 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд 153596,8 сая төгрөгийн ашигтай ажилласан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЖАРГАЛСАЙХАН